



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 35

Өлгий

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "г" заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Спорт цогцолбор болон "Б" заалны үйлчилгээний үнэ, төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга /Х. Хайнар /-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЛАЗАТХАН

000001

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2015 оны 03 дугаар сарын 06 -ны өдрийн  
35 дугаар тогтоолын хавсралт

**Биеийн тамир, спортын газрын спорт цогцолборын  
заалны үйлчилгээний төлбөр, хураамж авах журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл:**

- 1.1. Энэхүү журам нь Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборын зааланд спортын болон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах үед аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах, бодлого, БТС-ын газрын үйл ажиллагааны чиглэл, зорилготой уялдуулан заал ашиглалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.3. Үйлчлүүлэгч нь заал танхимыг ашиглах талаарх тодорхой мэдээлэлийг захиргаа, санхүүгийн албанд 14 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, график, төлөвлөгөөнд тусгуулан гэрээ байгуулж, зохих тарифын дагуу үйлчилгээний төлбөрийг хийнэ.
- 1.4. Үйлчлүүлэгч талын хүсэлтийг албан бичгээр болон амаар хүлээн авч заал ашиглалтын гэрээнд тусгаж гэрээ байгуулна.
- 1.5. Үйлчилгээний төлбөр хураамжийн орлогыг өөрийн орлого бүрдүүлэх эх үүсвэр болгох ба өөрийн орлогын хэмжээнээс давсан хэсгийг аймгийн орлогын дансанд төвлөрүүлнэ.
- 1.6. Заал ашиглах үйлчилгээний гэрээ, төлбөр тооцооны гүйцэтгэлд нягтлан бодогч хяналт тавьж ажиллах ба биелэлт хэрэгжилтийн явцын талаар газрын даргад танилцуулж байна.
- 1.7. Үйлчилгээний билет, бэлэн мөнгөний тасалбарыг зохих журмын дагуу Санхүү, төрийн сангийн хэлтэс баталгаажуулалт хийж олгоно.

**Хоёр. Заалны цаг ашиглалт, дотоод журам**

- 2.1.1 Зааланд зохиогдох аливаа арга хэмжээний үргэлжлэх хугацаа 5 /тав/ цаг хүртэл ба түүнээс дээш хугацааг бүтэн өдрийн тарифаар тооцно.  
Оройн 20.00 цагаас хойш нэмэгдэл төлбөр авна.
- 2.1.2 Тэмцээний удирдамж, шүүгчдийн бүрэлдэхүүн, спортын хэрэгсэл, материал хангамжтай холбогдсон асуудлыг үйлчлүүлэгч өөрөө хариуцах бөгөөд гадна талбай болон заал танхимд тавигдах реклам, сурталчилгааны материалыг үйлчлүүлэгч талтай тохиролцсоны үндсэн дээр байрлуулах буюу заалны зохион байгуулагчид хүлээлгэн өгнө.

2.1.3 Үйлчлүүлэгч шаардлагатай эд зүйлс, заал танхимыг тэмцээн эхлэхээс 1 цагийн өмнө бэлэн болгож хүлээлгэн өгнө.

2.1.4 Үйлчилгээний гэрээ байгуулсан боловч арга хэмжээ зохиогдохоос гурав хоногийн өмнө төлбөр тооцоогоо хийгээгүй тохиолдолд гэрээг хүчингүй болгон цуцалж болно.

#### **Гурав. Төлбөр тооцоо**

2.1.5 Спорт цогцолборын цагийн хөлс нь 50.000 /тавин мянган/ төгрөг, "Б" заал 30,000 /гучин мянга/ төгрөг, Спорт цогцолборын нэг өдрийн үйлчилгээний төлбөр 250,000 /хоёр зуун тавин мянган/ төгрөг, "Б" заал заал 150.000 /зуун тавин мянга/ төгрөг тус тус байна.

2.1.6 Хэрвээ хурал цуглаан, шашны аливаа зан үйл үйлдэх /бясалгал, номлол, цуглаан/ болон бусад олон нийтийг хамарсан цуглаан уулзалт, семинар, спортын бус арга хэмжээ зохион байгуулахаар бол заалны үйлчилгээний төлбөр /Спорт Цогцолбор/ цагийн хөлс нь 80,000 /наян мянган/ төгрөг, 1 өдөрт нь 400,000 /дөрвөн зуун мянган/ төгрөг, "Б" заалны цагийн хөлс нь 50,000 /тавин мянган/ төгрөг, 1 өдөрт 250,000 /хоёр зуун тавин мянга/ төгрөг байна.

2.1.7 Аж ахуйн нэгж, байгууллага, хамт олноороо биеийн тамир, спортоор хичээллэх зорилгоор гэрээ байгуулан ажиллах тохиолдолд сарын хөлсийг спорт цогцолборт 150,000 төгрөг, "Б" зааланд 100,000 төгрөг байхаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах ба гэрээний дагуу 7 хоногт 1 удаа, 2 цагаар ашиглах.

2.1.8 Бялдаржуулах төвд хичээллэх үед 1 хүн цагт 2500 төгрөг, сард 30000 төгрөг төлөх ба 7 хоногт 3 удаа 2 цаг хичээллэнэ.

2.1.9 Заал ашиглах явцад гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор заалны үйлчилгээний төлбөрөөс гадна барьцаа хэлбэрээр 50,000 төгрөг тушаах ба Спорт цогцолборт мөрдөгдөх дотоод журам болон аливаа зөрчил гаргаагүй тохиолдолд буцаан олгоно.

2.1.10 Тус байгууллагатай ажил төрлийн холбоотой болон хамтран ажилладаг байгууллага, хувь хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдийн төлөөх олон нийтийн байгууллага, нийгмийн төлөөх тусгай спортын арга хэмжээ зохиогдох тохиолдолд байгууллагын даргын зөвшөөрөлтэйгээр үнэ төлбөргүй болон 50 хүртэл хувийн хөнгөлөлттэй тарифаар ашиглуулж болно.